Монгол Улсын Үндсэн хуулийн 47 дагаар зүйлийн 1-д "Монгол Улсад шүүх эрх мэдлийг гагчхүү шүүх хэрэгжүүлнэ", 49 дүгээр зүйлийн 1-д "Шүүгч хараат бус байж, гагчхүү хуульд захирагдана" гэж заасан үзэл баримтлал нь хууль тогтоогүй гүйцэтгэх эрх мэдлийн үйл ажиллагаанд шүүхийн байгууллагаас хяналт тавих эрх зүйн үндэслэлийг тогтоож өгсөн билээ.

Шүүгчийн нийгэмд эзлэх байр суурь, гүйцэтгэх үүрэг, хараат бус байдлыг хангах асуудлыг авч үзэхдээ шүүх эрх мэдлийн байгууллагуудаас шүүхийн оролцох оролцо, түүний эрх мэдлийг хамтад нь авч үзэх зайлшгүй шаардлагатай юм. Шүүхийн бие дассан, шүүгчийн хараат бус байдлын талаар тогтоосон эрх зүйн зохицуулалт бодит амьдралд биеллээ олж чадсан ихцэвэлт ардчилал жинхэнэ утгаараа хэрэгжих болопцоотой болох юм.

### Нэг. Шүүгчийн нийгэмд эзлэх байр суурь, гүйцэтгэж буй үүрэг

Шүүх эрх мэдэл нь хоёр үндсэн үргүйг гүйцэтгэдэг. Үүнд нэгдүгээрт: эрүү, иргэний хэрэг болон эрх зүйн бусад бүх маргааныг эцэслэн шийдвэрлэдэг, хоёрдугаарт: хууль тогтоох, гүйцэтгэх эрх мэдлийн байгууллагын үйл ажиллагаанд хуулиар тогтоосон хэмжээ хязгаарын дотор хяналт тавьж хэрэгжүүлдэг<sup>1</sup>. Дээрх

үргийг хэрэгжүүлэгч нь шүүгч бөгөөд уг асуудлыг шүүгч хараат бус байж гагчхүү хуулийн захирагдан шийдвэрэлж байх учиртай. "Монгол Улсын шүүхийн байгууллагаас 2004 онд нийт шийдвэрлэсэн эрүүгийн хэргийн 18,4 хувь нь, иргэний хэргийн 5,1 хувь нь өөрчлөгдж хүчингүй..."<sup>2</sup> болсноос үзэхэд нийт шийдвэрлэсэн эрүүгийн хэргийн 81,6 хувь, иргэний хэргийн 94,9 хувь нь хүчинтэй хэвээр батлагдан дун мэдээ гарсан нь шүүхээс эрүү, иргэний хэрэг хянан шийдвэрлэж буй ажиллагаа зохих хуулийн дагуу явагдаж байгааг тодорхойлсон гол үзүүлэлт болж байна,

Тэгэвл ягаад шүүхийн нэр хүнд олон түмний дунд сайнгийг байна вэ?

Шүүхээс шийдвэрлэсэн хэргийн шийдал нь хэргийн аль нэг талд таалагдаа угтгээс шүүхийн шийдвэрийг хуулийн бэлжээрин үзэмжээр тайлбарлах, сонин хэвлэлд хандаж серег ойлголт өгөх явдал нь шүүхийн нэр хунддад зохих хэмжээгээр нөвлөөдөр. Шүүх, шүүгч энэ бүхэнд хүлээцтэй, дуугуй байх зарчмыг барьсаар ирсан. Энэ байр суурь ч зөв гэж үзнэ. Шийдвэрлэсэн хэрэгээ зөв гэж шүүгч тайлбарлавал тухайн хэргийн яласн талд ашигтай тайлбарласан гэх ойлголт төрөх магадлал ил юм.

Харин шүүхийн үйл ажиллагаа, шүүхээс гарч буй тоогот, шийдвэрүүдийг /нууцад хамаараахас бусад/ олон нийтэд

нээлттэй болгох ажиллагаагаа зохион явуулах зорилгоор мэдээллийн лавлах товчоо ажиллуулах, шүүхийн шийдвэрийг Нийслэлийн шүүхийн номын санд тавих зэргээр нилээд ажил байгаа боловч шүүхийн төсөөт энэ ажилд зориулсан зардал батлах зайлшгүй шаардлагагаар байна.

Шүүгчийн гүйцэтгэж буй дээрх үйл ажиллагаанаас гадна шүүгчийн нийгэмд эзлэх байр суурьг дараах байдлаар тодорхойлон авч үзэж болох юм. Үүнд:

- Х у ү լ ь тогтоогчоос баталсан хуулийг мөрдлөг болгон хамгаалж, нийгэм дээ эрх зүйн дээжурам орших баталгаа нь болдог.

-Аливаа хуулийн этгээд, иргэнд хуулиар олгогдсон эрх, эрх чөлөөг хамгаалж байдаг.

-Хууль бус үйлдлээс териийн болон бусад байгууллагыг хамгаалах баталгаа болдог.

-Х у ү լ ь р тогтоосон хэм хэмжээг зөрчсөн үйлдлийг териийн албадлагаар зогсоодог.

-Шүүхээс гарч буй эрх зүйн акт нь шударгай ёсны баталгаа болдог.

-Шүүхийн үйл ажиллагаа нь олон нийтдэд хууль ёс, итгэл үнэмшлийн баталгаа болж байдгаараа онцлог юм.

"Шүүхийн хаалга" татах, "шүүхэд дуудуулахаас" айж эмээх, нэр алдар нь хугарсан мэт үзэж байсан үзэл сэтгэлгэнээс

<sup>1</sup> Шүүх эрх мэдлийн талаар Үндсэн хуулийн үзэл баримтлалын тухай. Б.Чимид, 2001 он.

<sup>2</sup> Монгол Улсын Дээд шүүхийн мэдээлэл. 2005 он. Дугаар 001/74/

монголчууд ангижирч "шүүхэд хандана" шүүхээр заргандлаад гэж бардамхан бас элгэмсэг сэтгэлээр шүүгч, шүүхэд хандах болсон нь шүүхийг ойгдох, хундатэх, эрх, эрх ашигт нь хамгаалахад шүүх, шүүгч чухал үргэг гүйцэтгэдэг гадгийг ухаарч мэдэж, хүртэж мэдэрсний илрэл, монголын эрх зүйн сэтгэлзүйний том ялалт, асар их дэвшил мөн.

Шүүхийн тухай олон нийтийн санаа бодол судалгаанд оролцогчдын 43 хувь нь эршиг нь хөндөгдхөд би хаашаа хандажаа мэдэж гэж хариулсанар бас давхар нотлогдом байна.<sup>1</sup>

Тухайлбал: Иргэний эрх зүйн харилцаанд оролцогч талууд гэрээз байгуулахдаа эв зүйлээр зохицохгүй бол шүүхээр асуудлыг шийдвэрлүүлнэ гэж тохиролцог нь нийтлэг ойлголт болсон байна. Энэ нь шүүхэд хандах итгэл, зөрчигдсөн эрхээз хамгаалаулах хүсэлт байгааг харуулж байна.

Шүүгч нарын хийж буй ажлын ачааллын талаар авч үзье. Одоо шүүхийн байгууллагад бүгд 407 шүүгч ажиллах байна. 2004 онд эрүүгийн 9473 хүнд холбогдох 7021 хэрэг, иргэний 23290 хэрэг, захирагааны 145, захирагааны арга хэмжээ авахуулах хүсэлт 12127, ялтныг хорих ял эдлээзээс хугацаанаас ёмне тэнсэн суллах тухай материал 2107, баривчлах зөвшөөрөл олгох эсэх асуудлаар 7465 материал эзрг бүгд 57115 хэрэг материалыг хүлээн авч шийдвэрлэхээс.

Мөн Монгол Улсын шүүхүүд 10035 өргөдөл гомдол хүлээн авч зохих ажиллагаа хийжээ. Үүнээс гадна эрүү, иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад ЭБШХ, ИХШХШТ хуулийн заасан олон ажиллагаа хийж олон зуун эрхийн акт гаргадаг билээ.

Дээрх ажиллагаанаас үзүүлэд шүүгч нараас нийгмийн ёмне хүлээсэн үүргээ гүйцэтгэхийн тул маш их ачаалалтай ажиллаж, шүүх эрх мэдлийн байгууллагын ёмне тавигдсан зорилтыг зохих ёсоор хэрэгжүүлж, өөрийн ажил мэргэжил, өргөсөн тангарагтаа үнэнчээр ажиллаж, шүүхийн хүнд ачааг үүрч явна гэж дүгнэж байна.

#### *Хоёр. Шүүгчийн хараат бус байдлыг хангах нь:*

Шүүгчийн хараат бус байдал гэдэг нь гагцхүү хуулинд захирагдан хэнтэй ч нелененд автахгүйгээр аливаа хэрэг маргааны бие дааж шийдвэрлэхийг хэлнэ. Энэ ойлголт хүмүүнлэг, ардчилсан иргэний нийгэм байгуулах зорилтыг Үндсэн хуулиараа тунхагласан ёнөө үед улам чухлаар тавигдаж байна.

Ардчиллыг бодитоор хэрэгжүүлье гэвэл шүүхийн бие даасан, шүүгч хараат бус байх эрх зүйн болон эдийн засгийн бүх нөхцлийг хангах шаардлагатай юм.

"Шүүх юуны ёмне хуулияа дээдэлдэг, шударга, хүнлэг, ёс зүйн дархлаатай байх учиртай"<sup>2</sup> Шүүгчийн хараат бус байдлыг хоёр талтай үзэж болно. Үнд:

Нэгдүгээр:  
Мэргэжлийн;  
Хоёрдугаарт:  
Хувийн.

Мэргэжлийн гэдэгт аливаа хэрэг маргааны хуулийн дагуу оновчтой зөв шийдвэрлэх чадлаг байх шүүгчийн мэргшсан чадварыг хэлнэ. Үүний тулд онолын өндөр мэдлэгтэй, хууль хэрэглэх ур чадвар сайтай байх, хэргийг хуулийн дагуу голч нуруутай шийдвэрлэж байвал зохино.

Хувийн гэдэгт хэрэг маргааны шүүгч хараат бусаар шийдвэрлэх тал бүрийн баталгааг төрөөс бурдгуулсан байхаас гадна шүүгчийн албан тушаалд өөрийгөө бэлтгэсэн байх чадвар хамаарна. Энэ нь аливаа хууль бүс үйлдлээс, ёс суртахуунгүй байдлаас, ўл мэдэхээс, хариуцлагагүй байдлаас бүрэн чөлөөлгөдсөн бай шаардлагатай. Үүнээс гадна шүүгч биеэ зөв авч явах чадварыг бүрэн эзэмшиж, ямарваа хэлбэрээр эс зүйн зерчил гаргахгүй байх, зан харьцааны сойлтой байх чадварыг бий болгох ёстай.

2004 онд шүүгчийн ёс зүйн болоод хариуцлагагүй ажиллагааны талаар шүүгчийн сахилгын хороонд 215 өргөдөл гомдол ирснээс 12 нь буюу 5,5 хувь нь үндэслэлтэй нь тогтоогдож Монгол Улсын Шүүхийн шүүгчийн ёс зүйн дүрэмд зааснаар сануулах, 1 жил хүртэж зэрэг дээ бууруулах арга хэмжээ аваагдсан байна.

Зөрчлийн байдлыг авч үзвэл тойргийн журмаар харяг хуваарилах ажиллагааг зөрчиж иргэний нэхэмжилгийн вөртөө авах, хэрэг хянан шийдвэрлэх хугацааг үндэслэлгүй кэтрүүлэх, хэргийн зохигчтой зүй зохисгүй харьцах зэрэг зөрчил гаргажээ. Шүүгчийн талаар ирсн гомдол, мэдээллийн 94,5 хувь нь үндэслэлгүй байна.

2002.9.1-нээс эхэн мердсэн "Шүүхийн тухай хууль"-ийн 54 дугээр зүйлийн 54.1.2 дахь хэсэгт "Шүүгчийн зэрэг дэвийг б сараас 1 жилийн хугацаагаар бууруулах" арга хэмжээ авахыг сахилгын шийтгэлийн нэг төрөл болгон заасан. Эмне нь энэ арга хэмжээ байсан. Цалин хасас арга хэмжээг тортгуйлийн арга хэмжээ гэж үздэг.

Торгууль нь эрүүгийн

<sup>1</sup> Н.Лүндиндорж. Эрх зүйт төрийн төлөвшийн зарим асуудал. "Шинэ толь" сэтгүүл. 2003 № 42. 27, 28 дугаар тал

<sup>2</sup>"Шүүх эрх мэдэл-шинж зүүн" сэдэвт олон улсын онол-практикийн бага хурал дээр Монгол Улсын Ерөнхийлөгч Н.Багабандийн хэлсэн үнгэс

хариуцлагын төрөл гэдэгтэй эрдэмтэн судлаачид санал нэг байдгаас үзвэл шүүгчид энэ төрлийн арга хэмжээ авах хуулийн зохицуулалтыг Шүүхийн тухай хуульд тусгасныг хууль тоогочид эргэн хянан үзэх зүй ёсны шаардлага тавигдаж байна.

Шүүгчийн хараат бус байдлын эдийн засгийн баталгаанд цалин бууруулахгүй байх шаардлага байдал. Жишээ нь: АНУ-ын Үндсэн хууль болон Техас муж улсын Үндсэн хуулинд шүүгчийн цалинг бууруулж болохгүй гэж хуульчлан заасан байна.

Энэ бол тухайн улсын онцлогосо шалтгаалаагүй, харин шүүгч хараат бус байх эдийн засгийн баталгааны үндсэн зарчмыг Үндсэн хуулиараа баталгаажуулсан гэж үзж байна. Иймд энэхүү зарчмын ойлголтыг манай хуулинд тусгаж шүүгчийн зэрэг дав хасд арга хэмжээг хасах нь зүйтэй юм.

Үндсэн хуулийн 49 дүгээр зүйлийн 2-т "Ерөнхийлэгч, Ерөнхий сайд, Улсын Их Хурлын ба Засгийн газрын гишүүн, тэр, нам, олон нийтийн бусад байгууллагын албан тушаалтан, иргэн хэн болоч шүүгчээс шүүн таслах үүргээ хэрэгжүүлэхэд хөндлөнгөөс оролцож болохгүй" гэж заасан нь шүүгч хараат бус байдлаар ажлаа хэвийн явуулах эрх зүйн баталгааны нэг чухал заалт юм. Үүнээс гадна шүүгч хугацаагүй томилгодох, шүүгчийн амь нас, эрүүл мэндэй умirsan хохирлыг нөхөн төлөх, тэтгэвэр тоогоход олгогдох буцалгүй туслаамж, шүүгчийг өөр албан тушаанд шилжүүлэх, чөлөөлөх, отгруулах талаарх эрх зүйн хязгаарлалт, орон байраар хангах, эзлийн баталгааг гаргаж өгөх зэрэг нь шүүгчийн хараат бус байдлыг хангах эрх зүйн баталгааг болж өгдөг.

Эдгэр баталгаануудаас эрх зүйн зохицуулалтаас шалтгаалаагүй зөвхөн хэрэгжүүлэх арга механизмуу

шүүгчийн хараат бус байдалд серег хүндэрлэх учруулж буй орон сууцны талаарх асуудлыг жишиг болгон авч үзье.

Нийслэл, дүүргийн шүүхийн нийт шүүгчийн 35-аас 36 гаруй хувь нь өөрийн гасан орон сууцгүй байна. Үүнийг шийдвэрлэхийн тулд 10 жилийн хугацаатай сард 1 хувийн хүүтэй 15 сая төгрөгийн зээллэгт зарим шүүгч нарыг хамруулсан байна. Зээлтөлөлтийн байдлаас үзэхэд, 10 жилийн дараа 25 сая гаруй төгрөг болгож төлөх тооцоо гарч байна. Огт менгэгүй шүүгчид зөвхөн хүүнд 10 сая төгрөг өгөх эдийн засгийн болоплоо бий иоруу? гэдэг асуудал тулгарч байна. Сард төлөх төлбөр шүүгчийн сарын цалингаас ендөр гарч байгаа нөхцөлд ялж амьдрал нь баталгаатай байх вэ? гэдэг асуудал гарах нь зүйн хэрэг.

Иймд шүүгч нарыг орон сууцаар тэр хангах асуудлыг анхааралдаа авах шаардлага зүй ёсоор толгаруу байна.

2004 онд анхан шат, давж заалдаад болон хяналтын шатны шүүх 3 тэрбум 59,2 сая төгрөгийг улс, орон нутгийн орлогод оруулахаар шийдвэрлэжээ. Үүнээс үзэхэд шүүх улсын төсвөөс санхүүждэг хэдий ч улсадаа зохих хэмжээний орлого оруулдаг байна.

Энэ орлогын зохих хувийг төрөөр дамжуулан Улсын Их Хурлаас шүүгч нарын орон сууцны асуудлыг шийдвэрлэх боломж байна. Гагчхуу шүүгчийн хараат бус байдлаар ажиллас эдийн засгийн талын баталгааны нэг болох дээрх асуудлыг шийдвэрлэхд хууль тоогочийн санаачлагатай зайлшгүй шаардлагатай.

Шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэх хүнд, хариуцлагатай албыг шүүгч нарт тохoon томилсон бол ажилласных нь хэрээр цалинг боломжийн хэмжээнд тоогох нь шүүгчийн

хараат бус байдлын баталгааг бий болгоход чухал нелөө үзүүлнэ.

Дээрх байдлаас дүгнэлт хийж үзвэл шүүгчийн хараат бус байдлын талаарх эрх зүйн очныг дахин хянан үзэж тунхаглалын шинж чанартай зарим асуудлыг бодит амьдралд хэрэгжих боломжийг нарийвчлан зохицуулах шаардлага тулгарч байна.

Мөн шүүгч зөвхөн шийдвэр гаргах түвшинд ажиллах шаардлагатай. Гэтэл ажлын ачаалал, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журмыг хэрэгжүүлэх үүднээс бичиг техникийн ажилд ихэнх цагаа зарцуулж, гол ажил болсон шийдвэр гаргах түвшинд бага цаг зарцуулдаг одоогийн үйл ажиллагааг шинэчлэх шаардлагатай юм.

Негвэтийгүүр шүүгчийн ажиллагаа ямагт хүнтэй шууд холбогдож байгаараа шүүгчийн зан харьцааны асуудал нь шүүхийн ажлын нэг илэрхийлэл болж байдал. Шүүхийн ажлын нер их хөдөлмөрийн зарим шүүгчийн зан харьцааны долголдоос болж үнэлгэдэхгүй болох нь шүүгч хараат бусаар ажиллас нөхцлийг өөрөө бий болгож чадахгүйд хүрдэгийг анхаарах цаг болсон.

Шүүхээс гарч буй аливаа шийдвэрт хуулийн этгээд, иргэдээс хүндэтгэлтэй хандаж завалт биелүүлдэг эрх зүйн хүмүүжлийг олон түмэнд төлөвшүүлэх явдал нь төрийн бодлого байх ёстой.



## Ёоахим Кают : Хуулийн уялдаа холбоог сайжруулах хэрэгтэй

### Ёоахим Кают

ХБНГУ-ын Ньюренберг хотын Дээд шүүхийн иргэний тэнхмийн тэргүүн.

Монгол Улсад 1996 оноос байнга ажиллаж, амьдарч байгаа.

Монголын шүүгч, өмгөөлөгчдөд ИХШХШ эрх зүй ба аж ахуйн эрх зүйлээр хичээл зааж шүүгч-багш нарыг бэлдэн, жил болгон сургалтын материалыг нь бэлтгэдэг.

Иргэний хуулийн ерөнхий хэсгийн тайлбарыг бичсэн



ажлын хэсгийн ахлагч юм.

Түүний хуулийн чадварлаг, туршлагатай боловсон хүчин бэлтгэдэг хувь нэмрийг нь үнэлж Монгол улсын Шүүхийн ерөнхий зөвлөлөөс "Шүүхийн тэргүүний ажилтан" цолоор шагнасан байна. ГТХАН-ийн 10 жилийн ойн босгон дээр түүнтэй манай сурвалжлагч С.Дэлгэрзаяа уулзаж ярилцлаа.

**1996** оноос Монголын Шүүгчдийн сургалтыг Тагардан хийсэн. Ер нь Хуульчдын сургалтын үр дүнгийн талаараа тодруулна уу?

-1990 оноос хойш Монголд болсон шинчлэлийн дараа цоо шинэ бүтэцтэй, цоо шинэ зарчмуудад тулгуурласан шина хуулиуд гарсан. Эдгээр хуулиудыг хэрэглэдэг, практик дээр ажилладаг хуульчдын мэдлэгийг маш яяралтай сайжруулах шаардлага бий болсон. Онын мэдлэгээс гадна тэр хумууст тухайн үед тулгарч байсан гол бэрхшээл бол хэрэглэх арга, техники практиктогоогүй байсан явдал юм.

Аливаа шинэ эрх зүйт

эхлээд сургуульд нь заачихаад, заасан хүмүүстээ тодорхой хэмжээний практик туршлагасава хуваалцаж байгаад, тэгээд практик гаргах ажиллуулах ёстой байдаг /хуулийг хэрэгжүүлжээр/. Тухайн үед Монгол тийм боломж байгаагүй. Хэдийнээ практик дээр ажиллаж байсан хуулычдад цоо шина эрх зүйг дахин сургах заах боломж байгаагүй. Тийм учраас практик дээр ажилладаг хүмүүс бие биедээ мэдлэг, туршлагасаа харилцан солилцох замаар, аль эсхүл сургталт явуулах замаар бие биенийхээ тухайн шинэ эрх зүйт хэрэглэх чадварыг олох зайлшгүй шаардлага маш яяралтай тулгарсан.

Та яж, ямар шугамаар Монголд ирж ажиллах болв?

-Тухайн үед Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн яам гэх ХБНГУ-ын яам байсан. Энэ яам нь хөгжжик буй, шилжилтийн үйл явцдаа явж буй улс орнуудад төрөл бүрийн дэмжлэг туслалцаа узулзах ажлыг эрхэлдэг яам байdag. Тэр яам тухайн үед тандад эрх зүйн салбарт Монголд туслалцаа узулзах боломж байгаа эсэхийг судласан Ерөнхийдөө энэ замаар Монголтой холбогдох ирсэн юм.

Тухайн үед би Бавари муж улсын иргэн, шүүгч байсан. Тэгээд би шинэ замуу хуульчдын

практик сургалтгыг зохион байгуулж, өвөөр багшаар олон жил ажиллаад тодорхой хэмжээний турслага хуримтлуулсан байсан учраас Монголд ирж, энэ ажлыг эхлэхэд оролцсон. ХБНГУ-ын яамны даалгавраар ГТХАН гэдэг энэ байгууллага хөгжих буй оруундад, тухайлбал, Монголд төрөл бүрийн салбарт сургалтгыг биечлэн зохион байгуулдаг. ГТХАН нь хуульчдын сургалтгыг голлон зохион байгуулдаг юм.

**Монголын Шүүхийн тогтолцоо, хуульчид таныг 10 жилийн эмнэ ирж байхад, одоо байгааг харьцуулахад ямар давшил, өөрчлөлт гарсан гэж үзж байна?**

-Дэвшил гэж ярихын бол хэлэхийн аргагүй, зүйрэхийн аргагүй асар их өөрчлөлт гарсан гэж болно. Би гол төлөв шүүгч наарт, иргэний шүүгч наарт зориулсан сургалт хийдэг.

Иргэний хэрэг шийдвэрлэж байгаа шүүгчийн дунд өнөөдөр эн шинэ эрх зүйг гартаа оруулаад авчихсан, сайн ойлгож зөв хэрэглэдэг шүүгч нар олионоор бий болчихсон. 1996 онд тийм байгаагүй. Харин одоо гол хүндрэлүүдийн нэг нь юндуудаа оршиж байна гэхээр харьцаангүй болгино хугацаанд буюу суулийн 10-аад жилд суурь хуулиудыг яяралтай шийлгүү гаргах ёстой байсан учраас хуулиудыг хооронд нь төдийлен уялдаа холбоогүй, ялангуяа гарз, гарз хувьчлалтай холбоотой хуулиудыг Иргэний хуультай нь, хуулиудыг суурь хуультай нь уялдаа холбоог нь төдийлен сайн гаргаж амжаагүй. Цаг хугацаа ч бага байсан. Ирэздүйт тэд нарын уялдаа холбоог сайн гаргаад егчийн бол, өвөөр хэлбэл, хууль тогтоогчийн зүгээс, хуулийн төсөл боловсруулах, хууль батлагад байгууллагын зүгээс жоохон алдаануудыг нь

засаад егчих, хоорондын уялдаа холбоог нь сайжруулаад егчих нилээн томоохон ажлыг харьцаангүй болгино хугацаанд хийснийг дэвшил гэж нэрлээмэргүй байна. 1996 онтой харьцуулбал, эрх зүйн отг өөр орчин буй болжээ.

**Та Иргэний хуулийн өрөнхий хэсгийн тайлбарыг бичсэн ажлын хэсгийн ахлагчаар ажилласан. Түүнийээ талаар сонирхуулна уу?**

-Тайлбар гэдэг маань юу юм юу? Гэхээр хамгийн гол, нэгдүгээрт тавигдах ач холбогдол нь угаасаа хуульч хүн, шүүгч хүн тодорхой хэргийг шийдвэрлж хуулийг хэргэлж байхдаа туслах материал болгож ашиглагдаж байгаа, хамгийн тэргүүн ээлжинд ашиглагдах ёстой материал байдаг.

Тайлбарыг бол томоохон далайтай зүйрлүүлж болно. Юу гэсэн уг вэ? Гэхээр тэр далайд шаардлагатай, ач холбогдолтой маш олон мэдээлэл орсон байдаг, нөгөө талаараа тэр маань тэгээд зүгээр байгаад байж болохгүй, түүнд байгаа шинэ нэмэлт мэдээллүүд цутгагдаж байх ёстой. Нөгөөтэйгүүр энэ нь өөр нэг сэдийн хөндөк байгаа. Тэр нь хэвлэл мэдээллийн асуудал. Хуульчдын өврийднээр хүндээс эхлээд явваандаа интернет, онлайн бух хуульчдын доодот мэдээллийн нийтэд түгээд, ялангуяа шүүхээ гарч байгаа шүүхийн шийдвэрүүдийг нийтэд чөлөөтэй хэвлэн нийтэлдэг, шүүэл, хууль хяналтын бусад байгууллага өөрсдийнхөө хийж буйж ажлыг ард түмэнд зөв ойлгуулах, таниулах, харилсан мэдээлэл солилцож газд илүү ач холбогдолтой асуудал. Өөрөөр хэлбэл, хуульчдын ч юмуу жинхэнэ өөрийн гэсэн орчинг тэр дотроосоо хуульч нь ч өөртэй

хэрэгтэй мэдээллээ тэрэн дотроосоо авдаг, ард түмэн ч шүүх, хууль хяналтын байгууллагын талаар зөв ойлголттой болох тал дээр ихээхэн ажил хийж ёстай.

**Одоо яг та ямар сургалт зохион байгуулж байна вэ?**

-Энэ долоо хоногийн хувьд бид нар Монголын шүүгч багш наарт зориулсан сургалт зохион байгуулж байна. Энэ хүмүүс маань эргээд тэнд сонссон, сурсан мэдээллээ бусад шүүгч наарт тараах, түгээх үүрэгтэй хүмүүс байдаг. Сэдэв нь шүүхийн шийдвэрлийн бичилтийн арга, техникигээс нэртэй. Өөрөөр хэлбэл, нэгдүгээрт, хүн, шүүхийн цагийг, аль болох нөөц баялагaa харамалгүйгээр, боловсон хүчиний ч юмуу, цаг хугацаагаа, нөөц баялагaa бага, дээмий юманд үрэлгүйгээр, хөөрдүгэвэрт ард Иргэд буюу тухайн маргладгач талудаа тухайн шийдвэрийг аваад ойлгомжтой, уншаад ойлгохуйц, мөн дараах шатны шүүхүүд уншаад ойлгохуйц тийм тодорхой найруулагдсан, гэхдээ товч бөгөөд гол юмыг тусгасан шийдвэрийг хэрхэн бичих вэ гэдэг тал дээр илүү ярилцана.

Хөөр дахь долоо хоног дээр анхан шатны бүх шүүхүүд болох сум, сум дундын, дүүргийн шүүхүүд дээр үндэсн зарчмууд, практик дээр гарч байгаа ямар хүндрэлүүд байна түүн дээр бид нар санал бодлоо солилцож сургалтаа явуулах юм.

**Цаг гаргаж бидэнтэй ярилцсан танд баярлалаа.**



## Захиргааны хэргийн шүүхийн шийдвэрт шийдвэр гүйцэтгэх арга, журмыг тодорхойлох асуудал



Д.Оросоо

ИХЗҮТ-ийн эрдэм шинжилгээний  
ажилтан/

### Нэг. Шийдвэр гүйцэтгэх арга, журмын тухай ойлголт

ЗХХШТХ-ийн 78 дугаар зүйлийн 78.2 дахь хэсэгт заасны дагуу ЗХШ нь гаргаж байгаа шийдвэртээ тухай шийдвэрийг биелүүлэх буюу гүйцэтгүүлэх арга, журмыг тодорхой заас үүрэгтай. Энэ нь ЗХХШТХ-аар шүүхийн шийдвэрийн тогтоо хэсэгт тавигдаж буй нэг гол шаардлага болно. Учир нь хариуцагч шүүхийн шийдвэрийг (сайн дураар) биелүүлэгүй тохиолдолд тухайн шийдвэрт заасан шийдвэр биелүүлэх буюу гүйцэтгүүлэх арга, журмын дагуу шийдвэрийг албадан гүйцэтгэх ажиллагаатай талаар ямар нэг намэлт, өөрчлөлт ороогүй аж.

Захиргааны байгууллага, албан тушаалтан ЗХШ-ээс гаргасан шийдвэрийг сайн дураараа биелүүлэх үүрэгтэй. ЗХХШТХ-ийн 5 дугаар зүйлийн 5.2 дахь хэсэгт “Захиргааны хэргийн шүүхийн хүчин төгөлдөр актыг Монгол Улсын нутаг дэвсгэрт байгаа холбогдох бүх байгууллага, албан тушаалтан, иргэн заавал биелүүлнэ.”, 78 дугаар зүйлийн

78.1 дахь хэсэгт “Хэргийн оролцогчид захиргааны хэргийн шүүхийн шийдвэрийг хуулийн хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн биелүүлэх үүрэгтэй” гэж заасан байдал.

Хэрэв ЗХШ-ийн шийдвэрийг хариуцагч тогтоосон хугацаанд сайн дураар биелүүлээгүй бол шүүхийн шийдвэр гүйцэтгэх журмаар албадан гүйцэтгэнэ. Албадан гүйцэтгэх ажиллагаанд ИХШХШТХ болон Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд заасан иргэний хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны журмыг зарчмын хувьд баримтлана.

Захиргааны хэрэг хянан шийдвэрэлэх тухай хууль (2002.12.26) батлагдсантай холбогдон Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд (2002.01.10) захиргааны хэргийн шүүхийн шийдвэрийг хэрхэн гүйцэтгэх ажиллагааны талаар ямар нэг намэлт, өөрчлөлт ороогүй аж.

Харин Улсын Дээд шүүхээс 2003 оны 5 дугаар сарын 5-ны өдрийн №11 тогтоолоор Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн зарим зүйл, хэсэг, заалтыг тайлбарласан байна. Уг тайлбарт: Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 10.1.1-д заасан “Иргэний хэргийн талаар гарсан шүүхийн шийдвэр” гэдэгт захиргааны хэрэг шийдвэрлэсэн анхан шатны шүүхийн шийдвэр, давж заалдах шатны шүүхийн магадлал, хяналтын шатны шүүхийн тогтоол хамаарна гэж заажээ.

Энэ нь ЗХШ-ийн шийдвэрийн гүйцэтгэл нь иргэний

хэргийн талаарх шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны нэгэн адил журмаар явагдана гэсэн уг юм.

ЗХХШТХ-ийн 72 дугаар зүйлийн 72.5, 78 дугаар зүйлийн 78.2 дахь хэсэгт заасан шийдвэр биелүүлэх “арга” гэдэг нь шийдвэрийг нэг бол сайн дураар биелүүлэх эсхүл албадан гүйцэтгэх тухай, харин “журам” гэдэгт хариуцагч болон шийдвэр гүйцэтгэгч шүүхийн шийдвэрийг биелүүлэх буюу гүйцэтгэхийн тулд ямар үйлдэл хийхийг, “хувацаа” гэдэгт шийдвэрийг сайн дураар, эсхүл албадан гүйцэтгэх эхэлж хугацааг тус тус ойлгоно.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай Монгол Улсын хуулийн 67 дугаар зүйлд тодорхой үйл ажиллагаа гүйцэтгүүлэх, эсхүл тодорхой үйл ажиллагаа гүйцэтгэхийг байхыг хариуцагчид даалгасан шийдвэрийг гүйцэтгэх тухайд барилга, орон байраас нүүлгэн гаргах, хүүхдийг эзгэх, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчид шилжүүлэх, мөн ажлаасаа халагдсан хүнийг ажилдн буцаан авах эзргээн хэдэн тохиолдлыг албадан гүйцэтгэхээр заасан байдаг.

Харин захиргааны акт гаргахыг даалгасан болон уул актыг хүчингүй болгосон, түдгэлзүүлсэн зэрэг ЗХШ-ээс гаргасан шийдвэрийг хариуцагч биелүүлээгүй тохиолдолд шийдвэр гүйцэтгэлийн ямар ажиллагаа явуулахыг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд нэрлэж заагаагүй юм. Иймд ЗХШ нь шийдвэртээ ШШГТХ-ийн зарчим, үндэслэлүүдийг баримтлан тухайн шийдвэрийг захиргааны байгууллага, албан

тушаалтан үл анхаарч билүүлэсгүй тохиолдолд албадан гүйцэтгэх боломжтойгоор шийдвэр билүүлэх арга, журам, хугацааг тодорхойлох хэрэгтэй юм.

ЗХШ-д гаргасан нэхэмжилэлийн шаардлага, ЗХШ-ээс гаргах байгаа шийдвэрийн тэрлөөс хамааран шийдвэр билүүлэх буюу гүйцэтгэх арга, журам, хугацаа харилцан адилгүй байж болно.

ЗХШ-ийн шийдвэрийн тогтоох хэсэгт шийдвэр гүйцэтгэх арга, журам, хугацааг тодорхойлохсодоо гадна шийдвэр гүйцэтгэх ажиллагаа түдгэлзэх эсэх тухай асуудлыг тодорхойлох шаардлага бий.

Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шүүх хуралдан даргалагаа гаргасан шийдвэрийнхээ тогтоох хэсгийн агууллыг хуралдаанд оролцогчдод уншиж сонсгох бөгөөд шийдвэр уншиж сонсгосноор хүчин төгөлдөр болж хэргийн оролцогчид шүүхийн шийдвэрийг хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн билүүлэх үүрэг хүлээдэг.

Анхан шатны шүүхийн шийдвэр гарсны дараа давх заалдах эскулхяналтын шатанд гомдол гаргасан тохиолдолд уг хэргэг, маргааныг эцслэн хянан шийдвэрлэх хүртэл шийдвэр гүйцэтгэлийн ажиллагаа явагдахгүй байж гэсэн иргэний эрх зүйн процессын тусгай зарчмын байдал. Энэ зарчмын захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хамаарах уу?

Онолын хувьд тухайн шүүхийн шийдварт давх заалдах болон хяналтын журмаар гомдол гаргасан тохиолдолд уг шийдвэрийг билүүлэх, гүйцэтгэх ажиллагаа тудгэлзэж байж нь зүйтгээдэг. Гэвч ИХШШТХ-ийн 122 дугаар зүйлийн 122.1 дэх хэсэгт заасан "Давх заалдах болон хяналтын журмаар гомдол гаргасан тохиолдолд ч шийдвэр билүүлэх, гүйцэтгэх ажиллагаа явагдах (түдгэлзүүлэхгүй байх), уншиж сонсгосноор билүүлэх, гүйцэтгүүлэх эрх ЗХШ-д олгогдсон хэргэг.

Эрх зүйг амьдрал дээр "ашиглах", "дагаж мөрдөх", "биелүүлэх", "гүйцэтгэх" гэсэн хэлбэрээр хэргжүүлдэг. Үүний адил ЗХШ-ийн шийдвэрийг ч мөн ийм хэлбэрээр хэрэглэнэ. ЗХХШТХ-ийн 78 дугаар зүйлийн

78.2-т заасан "биелүүлэх" гэсэн уг нь эрх зүйг хэргжүүлэх бусад хэлбэр болох "ашиглах", "дагаж мөрдөх", "гүйцэтгэх" гэсний давхар илэрхийлж буйг гэж ойлгож болно.

Шүүхийн шийдвэр нь уншиж сонсгосноор хүчин төгөлдөр болно. Харин хэзээ эрх зүйн үйлчлэл үзүүлж эхлэх вэ гэдэг нь тусдаа ойлголт. Онолын хувьд гагцхүү эцсийн шийдвэр эрх зүйн үйлчлэл үзүүлээ.

Иймд ЗХШ-ийн хүчин төгөлдөр шийдвэр нь хэзээ эрх зүйн үйлчлэл үзүүлэх, хэзээнээс эхлан хэргэхийг вэ гэдгийг ЗХШ гаргаж буй тухайн шийдвэрийнхээ тогтоох хэсэг заавал тодорхойлоно. Өөрөөр хэлбэл, хэргэг хянан шийдвэрлэсэн шийдвэрийн тогтоох хэсэг шийдвэрийн билэлтийг түдгэлзүүлэх эсэхийг заана гэсан уг.

ЗХШ нь ИХШШТХ-ийн 122 дугаар зүйлийн 122.1 дэх хэсэгт заасан "Давх заалдах болон хяналтын журмаар гомдол гаргасан бол тэдгээрийг хянан шийдвэрлэх хүртэл шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явагдахгүй." гэсэн заалтыг зарчмын хувьд баримтлах нь зүйтэй юм. Шаардлагатай гэж үзэж байгаа бол энэ журмаас өөрөөр тогтоож болно.

#### *Хоёр. Шийдвэр гүйцэтгэх арга, журмыг хэрхэн тодорхойлох тухай*

Захиргааны хэргийн анхан шатны шүүх хэрэг хянан хэлэлцээд хуульд заасан 9 төрлийн шийдвэрийн аль нэг буюу холбогдох хэсгийг гаргана. Түүнийг давх заалдах болон хяналтын шатны шүүх хянаад хэвээр үлдээх, өөрчлөх эсхүл хүчингүй болгох шийдвэрийн аль нэгийг гаргана. Иймд юуны өмнө анхан шатны шүүхийн гаргасан 9 төрлийн шийдвэрт түүнийг билүүлэх, гүйцэтгүүлэх арга,

журам, хугацааг ялгамжтай тодорхойлоно гэсэн уг.

ЗХШ-ээс маргаан бүхий захирагааны акт хууль бус болох нь тогтоогдвол түүнийг хүчингүй болгосон, захирагааны байгууллагаас гаргасан акт нь илт хүчин төгөлдөр бус болохыг хүлээн зөвшөөрсөн зэрэг тодорхой эрх зүйн байдлыг тогтоосон, хэлбэржүүлсэн агуулга бүхий шийдвэрийг албадан гүйцэтгэх шаардлага бага байж болно.

Эдгээр шийдвэр нь веरөө аяндаа биелэгдэх шинж чанартай учир эрх зүйн харилцаанд оролцогч этгээд тухайн шийдвэрийг албадлагаяа бус веरөө ашиглах, дагаж мөрдөх, биелүүлэх замаар хэрэглэх юм.

Эрх зүйн ямар нэг акт хүчингүй гэдгийг тогтоосон байлаа гэхэд шийдвэр нь шууд л мөрдөгднө. Фөөрөө хэлбэл, уг шийдвэр тэртэй тэргүй веरөө биелэгдэх нь тодорхой буюу "self-executing" (веरөө биелэгдэх, хэрэгжих) байна гэсэн уг. Тийм болохоор энд шийдвэрийг албадан гүйцэтгүүлэх тухай ойлголт анхнаасаа отт шаардлагагүй болж байна. Шүүхийн иймэрхүү маягийн шийдвэрийг захирагаа ерөнхий утгаар нь явцын дунд, ургаслаар нь "биелүүлэх" ёстой. Тухайлбал, захирагааны шүүхийн шийдвэрээр татан авсан, эсвэл хүчингүй болгосон заалтыг хэрэглэхгүй байх гм.<sup>1</sup>

Харин захирагааны байгууллага, албан тушаалтны зүгээс ЗХШ-ийг үл хүндэтгэн хууль бус болох нь тогтоогдок хүчингүй болгосон акт, мөн илт хүчин төгөлдөр бус болсно байсан болно. Иймд шүүхийн шийдвэр унших сонсгосноор хүчин төгөлдөр болох учир уг өдрөөс эхлэн хариуцагч биелүүлэх үүрэгтэй.

Болгох зэрэг эрх зүйн зөрчил гарч болох юм.

Ийм тохиолдолд дээр дурдсан шийдвэрүүдийг веरөө аяндаа хэрэгжих шинж чанартай хэмзэн анхаарлын гадна орхиж болохгүй. Харин ч ЗХШ нь шийдвэртээ тухайн шийдвэрийг биелүүлэхэд чиглэгдсэн тодорхой арга, журам, хугацааг заах шаардлагатай юм. Тухайлбал, ЗХШ нь нийтээр дагаж мөрддэг захирагааны актыг хүчингүй болгосон бол энэ тухай хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтэд зарлагыг тухайн захирагааны байгууллага, албан тушаалтанд үүрэг болж болно, хэрэв нийтээр дагаж мөрддэг захирагааны актыг шүүд хүчингүй болгоход серэг үр дагавар үүсэхээр бол тодорхой хугацаанаа дараа хүчингүй болохоор зааж болно. Захирагааны байгууллага тухайн акт хүчингүй болохос өмнө багтаж веर журам гаргах эсхүл журмаа веерчлех боломжийг олгох хэрэгтэй юм.

Маргаан бүхий захирагааны акт хууль бус болох нь тогтоогдвол түүнийг хүчингүй болгосон, захирагааны байгууллагаас гаргасан акт нь илт хүчин төгөлдөр бус болохыг хүлээн зөвшөөрсөн зараг ЗХШ-ээс гаргасан шийдвэрт уг шийдвэрийг сайн дураар биелүүлэх арга, журам, хугацааг тодорхойлох боломжийг юм.

Учир нь уг захирагааны акт гарсан өдрөөсөө л хууль бус, илт хүчин төгөлдөр бус байсан болно. Иймд шүүхийн шийдвэр унших сонсгосноор хүчин төгөлдөр болох учир уг өдрөөс эхлэн хариуцагч биелүүлэх үүрэгтэй.

Захирагааны байгууллага, албан тушаалтнаас иргэнд ичуруулсан хохирлыг гаргуулах, хохирлын хэмжээг веерчилсэн шийдвэртээ зөвхөн уг шийдвэрийг сайн дураар биелүүлэх хугацааг зааж өгч болно. Учир нь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд төлбөр, хохирол гаргуулахтай холбоотой гүйцэтгэлийн алжиллагаат тодорхой заасан байдаг учир ЗХШ нь шийдвэрийг албадан гүйцэтгэх журмын талаар заах шаардлага байхгүй.

Хохирлын хэмжээг веерчилсэн, захирагааны актыг гаргахгүй байгаа явдал буюу эс үйлдэхүй нь хууль бус гэх тогтоогдсон бол шаарддагдаа захирагааны актыг гаргахыг тухайн захирагааны байгууллага, албан тушаалтанд даалгасан ЗХШ-ийн шийдвэрт шийдвэрийг сайн дураар биелүүлэх журам, хугацааг зааж өгч болно.

Шийдвэрийг сайн дураар биелүүлэх журмаар шийдвэрийг биелүүлэхийн тулд хариуцагч ямар үйлдэл хийхийд тодорхой, гүйцэд тодорхойлсон байх шаардлагатай. Хэрвээ шийдвэрийг сайн дураар биелүүлэхгүй бол шийдвэрийг биелүүлэх "журам"-ын дагуу албадан гүйцэтгэх ажиллагаа явуулж болно.

ЗХШ нь захирагааны байгууллагын нийтийн эрх ашгийн төлөө явуулж буй үйл ажиллагааг хягваарлах, хэвийн үйл ажиллагааг нь алдагдуулажгүй байх гэсэн зарчмын хүрээнд шийдвэрээ биелэгдэхэд үр нэлээ үзүүлэхүйц арга, журам, хугацааг сонгох нь чухал. ЗХШ нь захирагааны байгууллага, албан тушаалтнаас иргэнд ичуруулсан хохирлыг гаргуулах, хохирлын хэмжээг веерчилсэн шийдвэртээ зөвхөн уг шийдвэрийг сайн дураар биелүүлэх хугацааг зааж өгч болно. Учир нь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд төлбөр, хохирол гаргуулахтай холбоотой гүйцэтгэлийн алжиллагаат тодорхой заасан байдаг учир ЗХШ нь шийдвэрийг албадан гүйцэтгэх журмын талаар заах шаардлага байхгүй.

Төлбөр тогтоосон захирагааны актын төлбөрийн хэмжээг багасгасан, нэхэмжлэлийг бүхэлд нь хэрэгсэхгүй болгосон тухай шийдвэрт шийдвэр биелүүлэх арга, журам, хугацааг заах шаардлага байхгүй. Учир нь

<sup>1</sup>"Ханнес Зайдел"-ийн сан, "Эрх зүйн боловсрол" академи, "Захирагааны шэргийн шүүх: Монгол дахь шинэтгэл, дэлхийн улсуудын жишиг", УБ.2004 он. Доктор В.Дүрнэр. "Захирагааны шүүхийн шийдвэрийг биелүүлэх нь" илтгэл. 240 дэх тал

захиргааны байгууллага, албан тушаалтан гаргасан шийдвэрээ өөрөө хэрэгжүүлэх, биелэлтийг нь хангуулах үүрэгтэй.

Захиргааны байгууллага бусдад хандан гаргасан шаардлага нь зохих ёсоор биелэлээгүй тохиолдолд өөрөө албадлагын журмаар гүйцэтгүүлэх ёстой болдог. Өөрөөр хэлбэл, захиргааны байгууллага шийдвэрийнхээ гүйцэтгэлийг хариуцна гэсэн уг. Захиргааны байгууллагаас ийнхүү шаардлагаа өөрөө хариуцан гүйцэтгүүлж буй байдал нь харин иргэдийн хувьд боломжгүй байдал.

Иргэд нь өөрсдөө албадлагын аргыг хэрэглэх ямар ч боломжгүй учраас бусдад гаргасан шаардлагаа шүүхийн журмаар барагдуулах хэрэгтэй болдог.<sup>1</sup>

Иймд онолын хувьд шүүхийн шийдвэр гүйцэтгэл, захиргааны байгууллагын шийдвэр гүйцэтгэл гэсэн ойлголтыг ялгаж үздэг.

#### *Гурав. Шийдвэр биелэгдэх баталгааг хэрхэн хангах талаар*

ЗХХШТХ-ийн 5 дугаар зүйлийн 5,3 дахь хэсэгт “Захиргааны харгийн шүүхийн актыг биелүүлээгүй этгээдэд энэ хууль, Эрүүгийн хууль болон хууль тогтоомжийн бусад актад заасан хариуцлага хүлээнгэнэ.” гэж заасан байдал.

Шүүхийн шийдвэрийн биелэгдэх нэхцлийг хангахын тулд шүүхийн шийдвэрийг биелүүлэхгүй бол захиргааны болон эрүүгийн хариуцлага хүлээнгэх тухай шийдвэртээ дурдаж болох юм. Германы

Захиргааны Шүүхийн тухай хуулийн 172 дугаар зүйлд захиргааны байгууллага шүүхийн шийдвэрийг биелүүлээгүй тохиолдолд анхан шатны шүүх шийдвэр гарган:

Уг захиргааны байгууллагыг 10 маян хуртэл европоор торгохыг хугацаа заан сануулах;

Заасан хугацааг хэтрүүлбэл дээрх мөнгийг гаргуулахаар заасан байдаг байна. ЗШТ хуулийн 172-т албадлагын өөр агаар хэмжээний тухай дурдаагүй байна.<sup>2</sup> Энэ нь захиргааны байгууллага шүүхийн шийдвэрийг биелүүлээгүй тохиолдолд торгууль ногдуулах замаар шүүхийн шийдвэр биелүүлэхийг албадах буй хэрэг юм.

Хэрвээ шүүхийн шийдвэрийг тогтоосон хугацаанд биелүүлэхгүй бол Эрүүгийн хуулийн 258 дугаар зүйлийн 258.1-д (Шүүхийн шийдвэрийг биелүүлэх) заасан хуулийн хүчин төгөлдөр болсон шүүхийн шийдвэр, магадлал, шүүхийн тогтооыг санаатай биелүүлэгүй гэсэн үндэслэлээр эрүүгийн хариуцлага хүлээнгэх үндэслэл болно.

Энэ нь шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх буй ажиллагаа биш боловч шүүхийн шийдвэрийг биелүүлэх, гүйцэтгүүлэхэд чухал нөвлөтэй юм.

Эрүүгийн хуулиар шүүхийн шийдвэрийг биелүүлэхэд чиглэгдсэн уян хатан зохицуулалтыг хийж егсан байдал. Тухайлбал, эдгээр зохицуулалтыг авч үзвэ.

Захиргааны хариуцлагаын тухай хуулийн 30 дугаар зүйлийн (шүүхийг үл хүндлэх) 3 дахь

хэсэгт шүүхийн шийдвэрийг тогтоосон хугацаанд хундатгах шалтгаангүйзэр биелүүлээгүй буюу биелүүлэхэд саад учруулсан бол 500-10.000 төгрөгөөр торгох, мөн 30 дугаар зүйлийн 4-т (Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн албаны ажилтын хууль ёсны шаардлагыг үл биелүүлэх, заналжийлэх) шийдвэр биелүүлэхээс санаатайгаар зайлсхийсан бол 5000-10,000 төгрөгөөр торгох шийтгэл ногдуулахаар заасан. Мөн Эрүүгийн хуулийн 258 дугаар зүйлийн 258.1-д (Шүүхийн шийдвэрийг үл биелүүлэх) хуулийн хүчин төгөлдөр болсон шүүхийн шийтгэх тогтолцоол, шүүхийн шийтгэл, магадлал, шүүхийн тогтоол, шүүхийн захирамжийг санаатай биелүүлээгүй, эсхүл биелүүлэхэд нь зориуд саад учруулсан бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг таваас тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, нэг зуугасаа хоёр зуун тавин цаг хүртэл хугацаагаар албадан ажил хийгэх, нэгээс турван сар хүртэл хугацаагаар баривчлах, эсхүл хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэхээр заасан байдал.

Эрүүгийн хуулийн 258 дугаар зүйлд заасан (Шүүхийн шийдвэрийг үл биелүүлэх) гэмт хэрэг сэхижигнэр тооцогдсон, ялалгадгачаар татагдсан, ял шийтгэгдсэн этгээд шүүхийн шийдвэрийг биелүүлсэн бол эрүүгийн хариуцлагаас чөлөөлгөдгөн.

Иймд ЗХШ шийдвэртээ шүүхийн шийдвэрийг тогтоосон хугацаанд биелүүлэхгүй бол Захиргааны хариуцлагаын тухай хууль болон Эрүүгийн хуульд заасан хариуцлага хүлээнгэх талаар дурдаж болох юм.

<sup>1</sup>П.Одгэрэл. “Захиргааны эрх зүйн ерөнхий ангид”, УБ. 2004 он. 173 дахь тал

<sup>2</sup>Ханснес Зайдэлт-ийн сан. Эрх зүйн боловсрол академи, “Захиргааны харгийн шүүх: Монгол дахь настнээг, далхийн улсуудын жишиг”, УБ. 2004 он. Доктор В.Дүрнэр. “Захиргааны шүүхийн шийдвэрийг биелүүлэх нийтлэл. 244 дахь тал

## ГЭМТ ХЭРГЭЭС УРДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АЖИЛД ХОЛБОГДОХ ЗАРИМ АСУУДАЛ

**Түүх сөхвэл:**

1921 оны 7 дугаар сард Нийслэл хүрэг чөлөөлж, Ардын тэр засгийн газрын б дугаар хуралдаанаар дэг журам сахиулах жинхэнэ ард түмний эрх ашгийг хамгаалааг "Сэргийлэх цэрэг"-ийг байгуулсан.

Энэ нь Цагдаагийн байгууллагын суурийг тавьсан төдийгүй аливаа хэрэг явдлаас урдчилан сэргийлэх бодлогын эхлэл болсон юм.

1923 онд Засгийн газрын хуралдаанаар олон түмэнд зориулсан анхны "Хуулах бичиг"-т "Нийслэл хүрээнд газар аливаа хүн архи уух, мөрийн наадах, хэрүүлэх, шийн чагаар чимээс гаргах, гол усны аюул болох, хулгайлах, булаах зэрэг бүхий л гашуун самууныг цагдан байцаалгах"-ыг олон түмэнд сануулж, бас цаазалсныг зөрчвөс цээрлэн шийтгэх журмыг зөвшин баталсан байна.

Уг журамд "Яамнаас зохих газруудад хүргүүлэн тушаасныг веерийн харьтад газруудаас олонд зарлах тул... аливааг ухамсарлан мэдэж, хичээнгүйэнд дагаж явбаас зохиими" гэсэн заалт нь хэрэг явдлаас урдчилан сэргийлэх, түүгээр ч барагчийг тэр, захирагаанаас эхлээд нийт байгууллага, иргэдийн эрхэм үүрэг нь гаж тодотгох ёгсэн чухал баримт болсон юм.

Тэр үеэс эхлэн хууль ёсыг сахин билүүлэх, гэмт хэргээс урдчилан сэргийлэх



Л.Билгээ

/ЦЕГ-ын хэвлэл мэдээллийн ажилтан, хурандаа/

ажилд олон түмнийг татан оролцуулах талбар тухайн чийн нам, төрийн байгууллагуудас олон чухал арга хэмжээ авч байсан.

1941 онд МАХН-ын Төв хороо, Сайд нарын Зөвлөлийн хамтарсан 41 дүгээр тогтоогоор ардын цагдан сэргийлэхийн ажилд туслах сайн дурын бригадыг байгуулахаар шийдвэрлэж, дагаж мөрдөх журмыг баталсан нь гэмт хэргээтгээд, урдчилсан сэргийлэх ажилд ард олныг өргөн оролцуулах шийдвэртэй алхам болжээ. Энэ үеэс эхлэн иргэд, хөдөлмөрчдөөс цагдаагийн байгууллагад идэвхтэй туслах хөдөлгөөн амжилттай өрнөж ирсний учир улс орны үндэсний аюулгүй байдал, эрүүгийн нехцэл байдал тогтвориж, иргэдийн эрх чөлөөг хамгаалах асуудал баталгаажиж ирсэн.

1960 онд МАХН-ын Төв хорооны 170 дугаар тогтооолд "Хуула гурвалжилгааны ажлыг

олон хэлбэрээр зохиох, гэмт хэрэг, зөрчилд өртөх бозошгүй хүмүүсийг биечлэн ангилах, эргүүл шалгалтын ажлыг хүчтэй болгок хэргийг илрүүлэн арилгах нь нам, улс, олон нийтийн туслалицаанд түшиглэх ёстой" гэж зассан.

Мен онд гэмт хэргээтгээд тэмцэх, урдчилсан сэргийлэх ажлыг сайжруулах зорилгоор хуулийн байгууллагуудын ажлын холбоо, хамтын ажиллагааг сайжруулах тухай хуулийн дээд байгууллагуудын хамтарсан тушал гаргасан. Энэ бүхэн нь улс орны эрүүгийн нехцэл байдлыг эрүүлкүүлэх, гэмт хэргээс урдчилан сэргийлэх, ялангуяа Цагдан сэргийлэх байгууллагад туслах олон нийт (ЦСБТОН)-ийн бригад нөхөрлөлийн ажлыг сайжруулж, гэмт хэргийг ганцхан сэргийлэх төдийгүй ард иргэд нийтэрээ тэмцэх боломжийн нээж ёгсэн. Энэ нь тус оронд гэмт хэргийг үндэсээр нь "устгах" зорилтыг хэрэгжүүлэхдэд ард түмнийхээ өргөн туслацаа дэмжэгийг авч ажиллах ирээдүйтэй бодлого байлаа. ЦСБТОН-ийн бригад нь хэвээр журам, мөрдөн байцаах ажилд туслах, авто техникийн, галян сайн дурын, эсвэрийн сэргийлэгчдийн, залуучуудын ёмч хамгаалах бригад, зөвлөл, бүлэг гэж төрөлжсөн хэлбэрүүдэд шилжик 40 шахам мянган гишүүд, хөдөлмөрчдийг эзээцэдээ нэгтгэсэн сайн дурын бие даасан байгууллага болтлоо хөгжин дэвшижээ.

Иймээс тэдний үйл ажиллагааг улам идэвхжүүлэх зорилгоор 1968 онд Цагдан сэргийлэх байгууллагад туслах хүчиний анхдугаар, 1974 онд

улсын 2 дугаар зөвлөгөөнүүдийг хохион байгуулан, гэмт хэрэгтай тэмцэхэд амжилт гаргасан олон зуун гишүүнийг төрийн одон медалиар шагнасты гадна, аймаг нийслэлд энэ ажлыг мөн хохион байгуулж, үйл ажиллагааг нь идэвхжүүлэх ажлыг жил бур хийдэг болсон.

Тэр засгаас ЦСБТОН бригадын энэ хэлбэр нь гэмт хэргээс урьдчилан сэргийлэхдэд иргэдийн идэвхтэй цөөн хэсэг нь хамарч байгааг тэмдэглээд, энэ ажил нь бүх ард түмний үйл хэрэг байх ёстой гэж узж Ардын нөхөрлөлүүд, Нийгмийн хэв журам хамгаалах олон нийтийн төвүүдийг нутаг дэвсгэрээр нь байгуулсан сум, дүүрэг, хорооны засаг дарга нарын сонгох ажиллуулах болсон. Энэ нь гэмт хэрэгтай тэмцэх, урьдчилан сэргийлэхдэд олон түмний татан оролцуулах арлын нэг байлаа.

Ингэж гэмт хэргийн эсрэг нийтийн тэмцлийг өрнүүлэхэд тухайн үеийн нам, төрөөс тушттай болдого, зорилт дэвшүүлэн хэрэгжүүлж тодорхой арга хэмжээ авч байсан. Иймээс 1960-1980 -аад оны үед гэмт хэргийн гаралт буурч жилд дундажар 6000 гэмт хэргээ бүртгээдэх, хүчин амь насыг санаатай бүрэлгэх, хүчин дээрэм болон бүлэг хохион байгуулалттай хэргүүд харцангуй бага гарч, илрүулж ч ахицтай байсан түүхийг үүгүйсэг аргагүй.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх асуудлын тухайд:

Монгол улс 1990 онос ардчиллын замд орж, зах зээлийн системд шилжих болсон. Шилжилтийн энэ үеийг далимдуулан тухайн үеийн тэр, засгийн зарим удирдлагыг, албан тушаалтнууд ард түмний хөл цусаар бүтээгдсэн улсын Үйлдвэрүүд, эмч хөрөнгийг хувваан идэн, банкаа хөослон

гадаад дотоодод шилжүүлэн ажилгүйдэл, ядуурлыг бий болгосон. Улс орныг эмх замбаараагүй байдалд оруулсан. Хүний сурч боловсрох явдал ч хязгаарлагдаж, мөнгөөр илрэхийлэгдэх болсон.

Жигд дунджаар эрүүгийн 22 маян, иргэний 30 маян гаруй, захирагын 10 маянг хэрэг маргаан, зөрчил бүртгэгдэд болж, улс орны эрүүгийн нехцэл байдал ихээхэн хүндэрсан.

УИХ, Засгийн газраас энэ бүхэнд дүгнэлт хийж, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр хадаан хөтөлбөр төлөвлөгөөг боловсруулж ирсан.

1992 онд Монгол Улсын Ерөнхийлгэгийн дэргэд нийгмийн дэгжурам хангах түр зөвлөлийг, 1995 онд Засгийн газрын дэргэд тус тус байгуулж, 1996 онобос Хууль зүйн сайдад үйл үргийг хариуцуж л гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэх арга хэмжээг авсан. Монгол Улсын Ерөнхийлгэгчээс 1998 онд Обдуугаар, 2001 онд 25 дугаар зарлиг зэрэг хэд хэдэн чухал эрхийн акт гаргаж, Зохицуулах зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах дүрмийг шинчлэн баталж ажиллуулсан

Мен Монгол Улсын Засгийн газраас "Хүргайн гэмт хэрэгтай тэмцэх" /2002/, "Хүүхийн болон түүний эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үндэсний хөтөлбөр" /1999 он/, Монгол Улсын Засгийн газраас "Архидан согтуурахтай тэмцэх талаар авах зарим арга хэмжээний тухай" тогтоо /1994 он/, "Архидан согтуурахтай тэмцэх тухай"/2000 он/, "Согтууруулах удаа хэтрүүлэн хэрэглэсэн этгээдийг албанад эрүүлжүүлэх тухай"/2003 он/ Монгол Улсын хуулиудыг батлан гаргаж мөрдүүлсэн нь улс орны

хэмжээнд гэмт хэргээс урьдчилан сэргийлэхэд нелее узүүлж байна.

Монгол Улсын Засгийн газраас 1997 онд "Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай" Монгол Улсын хуулийг батлан, гэмт хэрэгтай тэмцэх, урьдчилан сэргийлэхэд нийтийн тэмцлийг өрнүүлэх чиглэлийг баримтласан.

Ингэж улс оронд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлж, ялангуяа Цагдаагийн байгууллагын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх албаны бүтэц, үйл ажиллагааг боловсронгуй болгон гэмт хэргээс урьдчилан сэргийлэх хэлтэс, төв, орон нутгийн цагдаагийн газар, хэлтэст гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилтын орон тоог баталж, зарим аймаг хотод гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тасгийг байгуулж, эрэ зүйн орчинг бурдлуулж игсэн.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэхэд төрийн болон төрийн бус байгууллага, иргэдийн туслалцааг авч ажиллаха, хамтын ажиллагааг сайжруулах зорилгоор гэмт хэргээс урьдчилан сэргийлэх хэлтэсийг "Олон нийттэй харьцах хэлтэс" болгон өөрчилж, ажлын чиг үүргийг тодорхойлсон.

Цагдаагийн байгууллага Монголын нээлттэй нийгэм хүрээлэн /Соросын сан/-тэй хамтран "Цагдаа олон нийтийн хамтын ажиллагаа" төслийг хэрэгжүүлж байна.

Энэ нь Монгол улсын Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааг өөрчлен шинчилж, эрх зүйн хариуцааг боловсронгуй болгох цагдаа-олон нийтийн хамтын ажиллагааг сайжруулах, цагдаагийн үйл ажиллагааг иргэншиүүлах, цагдааг олон түмний дотор үйлчилдэг, үйлчилгээний байгууллага болгон төлөвшүүлэх эхлэл тавигдаж байна.

**Гэмт хэрээс урьдчилан сэргийлэх хуулийн хэрэгжилтийн өнөөгийн байдал :**

1. Хуулийн дагуу бүх шатны Иргэдийн төлөвлөгчдийн хурал, нутгийн төр, захирагаад, яам, агентлаг, териийн бусад байгууллага, алба эрхэлсэн ажлынхаа хүрээнд гэмт хэрэгтай тэмцэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээг боловсруулж хэрэгжүүлэх ёстой. Бас холбогдох хулья тогтоомжийг мэдээлэх, сурталчлах, сургалт зохион байгуулахыг үүрэгтэй.

Мен гэмт хэргийн шалтгаан нөхцөлийг арилгахад чиглэсэн эдийн засаг, улс төр, эрх зүй, ёс суртахуун, хүмүүжийн болон зохион байгуулалтын чанартай урьдчилан сэргийлэх нийтлэг болон нэг бүрчилсэн арга хэмжээг явуулж, олон түмнийг энэ үйлст өргөнөөр татан оролцуулж юм.

Тухайн нутаг давсгэр дээр гарч байгаа гэмт хэрэг, түүний шалтгаан нөхцөлийг арилгах талаараа харьяа нутаг давсгэрт оршиж аж ахуйн изгэж, байгууллагаас зохиох байгаа ажлыг хэлэлцэн чиглэл оч, гэмт хэрэгээс урьдчилан сэргийлэх ажилд зориулан төсөөвс санхүүжүүлэх хөрөнгийн хэмжээг тогтоож өгөхөөр хуульчилсан.

Хөрөнгийн хэмжээг батлахдаа тухайн ажилд шүүхийн шийдвэр биелүүлэх, замын хөдөлгөөний болон хэв журмын зөрчлийг арилгах чиглэлээр тортосон мөнгийг улсын орлого болгосон, мөн торох ял ногдуулж төсөөвт тушаасан мөнгөнийн 40 хувьтай тэнцэх хэмжээний хөрөнгийг гэмт хэрэгээс урьдчилан сэргийлэх ажилд зориулахаар хуульчилсан.

Гэтэл ихэнх аймаг, дуургүүдгээнт хэрэгээс урьдчилан

сэргийлэх ажилд зарцуулах ёстой уг мөнгийг өөр зүйлд зарцуулнаар Засгийн газрын 1994 оны 106 дугаар тогтоолын гуравдугаар хавсралтаар батлагдсан "Цагдаагийн туслах ажилтан" гэдэг цагдаад туслах цорын ганц хүчиний талаахад хүргээд байгаа.

2."Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай" Монгол улсын хуулийн 3 дугаар булагийн 12 дугаар зүйлийн 1-д "Нутгийн захирагаан байгууллага харьяа нутаг давсгэрийнхээ хэмжээнд гэмт хэрэг, нийгмийн хэв журмын зөрчлөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг авахдаа:

- Иргэдийг нийтийн эргүүлд гаргах
- Хэв журмын урамшилтай эргүүл жижүүрийг томилох
- Нийгмийн хэв журмын хамгаалах олон нийтийн байцаагаар ажиллуулна гэж заасан.

Гэтэл энэ заалт төв, орон нутагт одоо болтол бүрэн хэрэгжихгүй гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд олон түмний туслацааг авах явдал тухвагчлалын шинж чанартай үргэлжилсээр байгаа юм.

Нутгийн төр, захирагаад иргэдийг нийтийн болон урамшилтай эргүүл, жижүүриэр ажиллуулах тухай Монгол улсын Хууль зүйн сайдын 1998 оны 57, 1999 оны 38 дугаар тушаалтуудыг хэрэгжүүлж биелүүлэх асуудал бараг эхлээгүйээс гэмт хэрэг, түүний дотор хулгайн гэмт хэрэг мен олон нийтийн газарт гэмт хэрэг үйлдэх явдал үргэлжилсээр байна.

Хулгайн гэмт хэрэг сүүлийн жилүүдэд бүртгэгдсэн нийт гэмт хэргийн 40-60 хувийг эзслээр л байна.

Өнөөдөр дээрэмдэх хэргийн 53.3, булаалтын 48.0, танхайрах гэмт хэргийн 28.7, хүн

амины гэмт хэргийн 19.7, хүчиндэх хэргийн 15.8, хулгайлаж гэмт хэргийн 4.5 хувь гудамж талбайд үйлдэгдсэн.

Улсын хэмжээнд ял шийтгэлгүй болох хувацаа дуусаагүй байсан уедээ буюу ял хойшлогдсон, ял тэнссэн, хоригоос сулгагдсан даавтан гэмт хэрэг үйлдэх нь аймаг, нийслэлд үргэлжилж зарим аймгуудад ёссэн.

Ялангуяа, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх хуулийн хэрэгжилтийг хангахад нутгийн төр, захирагаан байгууллагуд, оновчтой ур дун гаргахийг санаачлагчаар гаргаж, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх талаар олгож ёстой хөрөнгө, хүчиний зөв ашиглан гэмт хэргийг бууруулахад чиглэгдсэн арга хэмжээ, түүний дотор гэмт хэргээс урьдчилан сэргийлэх нэг бүрчилсэн арга хэмжээ ихэзжэн дутагдах байна.

Тэгвэл зах зээл хөгжсэн орнуудад цагдаагийн байгууллагыг хэрхэн дэмжих, гэмт хэргийн эсрэг нийтийн тэмцлийг яж өрнүүлж зохион байгуулж, хүч бололцоо нь яж ашигладаг талаар хэдэн жишиж толилуулаяа.

Сингапур Улсын цагдаагийн байгууллага гэмт хэрэгтэй тэмцэх зорилгоор цагдаагийн гэрээт ажилтан олноор ажиллуулж цалин олгодог. Мен "Цагдаагийн фонд" байгуулан цагдаагийн ажилтан илүү цаг ажиллах, тэтгэвр гарах, гачигдалтай үед нь тусандаг.

Япон Улсад цагдаагийн байгууллагын үйл ажиллагааг дэмжихтэй холбогдсон "Гэмт хэрэгээс сэргийлэх иргэний нийгмлэг", "Өсвөр үеийн ёв ташж хүмүүжлийн байгууллага", "Галын аюулаас сэргийлэх сайн дурын байгууллага", "Нутаг дэвсгэрийн иргэдийн

байгууллага", "Хөршийн холбоо" болон эмэгтэйчүүдийн нийгэмлэг, ахмадын нийгэмлэг, худалдааны гудамжны эвсэл зэрэг олон байгууллага "бүх салбарт гэмт хэрэг, осол, зөрчлөөс сэргийлэх" ўйл ажиллагааг явуулдаг.

Улс болон орон нутгийн захирагааны байгууллагас гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилсан сэргийлэх, здгэрэй байгууллагуудыг хөгжүүлэх, түүний ўйл ажиллагааг дэмжих зардлын санг байгуулж тусалдаг.

"Гэмт хэрэгээс сэргийлэх нийгэмлэгүүдийн холбоо" нь орон нутгийн засаг захирагааны нэгжид зохион байгуулгадан тэр засаг, хувийн хөвшийнхэнтэй нягт хамтран ажилладаг хүчирхэг томоохон байгууллага болсон байна.

Умард Ирландын хэмээгээр цагдаагийн байгууллагатай 110 хүндэтгэх хороо хамтарч ажилладаг. Эдгэр нь сайн дүрийн ундсан дээр байгуулгасан. Хорооны гишүүд 2 сард нэг удаа цагдаагийн дарга, хариуцлагатын урьж гомдол, санал, мэдээллээ солилцдог. Цагдаагийнхан ч ихэнх мэдээллийн тэднээс авдаг аж.

Гадаадын орнуудад ялангуяа, ХБНГУ, АНУ-д цагдаа наарт туслах "сайн дүрийнхан", "Ардын нэхэрлэлийн гишүүд" ажиллаж, хүмүүсийн энэ амгалан байдлыг сахиулж, хэрэг зөрчлөөс урьдчилсан сэргийлж байдаг.

Түүгээр ч барагчийн америкууд болон германууд орчин үеийн ертөнцдэг гэмт хэрэг газар авч гаарч байхад дан ганц төрийн цагдаа наарт найдаад хол яввахгүй үе эхэлж байна гэж үссэн аж. Ийм уед иргэд "өөрсдөө л өөрийгээ хамгаалах" номлол, үзэл санааг дэвшүүлэн ажилладаг.

Өнөөдөр АНУ-д 1.6 сая хувийн цагдаа ажиллаж байгаань

терийн цагдаа нараас гурав дахин их тоо гэсэн.

Хувийн цагдаа нар хар өнгийн сурлаг дүрэмт хувцастай, хүн даахын аргагүй хүнд бахим шаахайтай, сум нэвтэрдэгүй хантаавтай, "магнум" хэмэх гар буутай байдаг. Тэр бие томтой, үнхээр сурдмээр хүмүүс байдгаас багачууд тэднийг дууришинаа ний бий. Тэднийг нэг ёсоondoо "ардын нэхэрлэлийн гишүүд" гэж болох бөгөөд хүнд хүчүү нэхцэл бий болсон уед алба, байгууллагад туслаж ажилладаг. Орон сууцны хороолол, төмөр замын буудал, машин, тэрэгний зогсоол гээд хүн олонгийн газарт эргүүл хийж, хэв журам сахиулна. Тэдний цалинг иргэд, байгууллага гаргана. Тэд хэн нэгэн гэмт этгээдийн цагдаа иртэл барин саатуулж эрхтэй.

Сүүлийн уед иргэд цагдаа наарт итгэл алдарт хар хувцастнуудыг ажиллуулахыг хүснэгжэх болж, томоохон зарим хороолол гэхэд ард, иргэд өөрсдийн мөнгөөр уг салбарыг байгуулсан ажилласны үр дүнд хулгай дээрэм, хүн амины хэрэг эрс багассан байна.

Аляска мужид гэхэд л 300 орчим суурин газар байгаагийн томоохон хотод нь цагдаагийн газар ажилладаг. 60-600 хүн амтай 122 сууринд "аюулгүй байдлыг хамгаалагч" гэсэн нэртэй тусгай цалинч, орон тооны бус ажилтан хэсгийн төлөөлөгчийн удирдлагын доор ажилладаг. Тэднийн оршин суугчдын саналыг харгалзан шилж сонгон авч 42 хоногийн дамжаанд сургаж, бэлтгээд цагдаагийн бус дурсмыг хувцасаар ханган ажилд нь оруулдаг.

Мен Герман Улсад "Иргэний хамгаалалт" буюу Ардын нэхэрлэлийнхэн ажилладаг. Кельн хотын хороолын оршин суугчид сар бүр 100 маркийн телбр телж, хувийн харуул хамгаалалтын пүүс ажиллуулсны ачаар тэр

